

MU-NB-3:22LB



Мандах Их Сургууль

Боловсролын байгууллагын менежментийн тогтолцоо ISO21001:2018 гарын авлага / эмхт. С.Энхтуяа, П.Болормаа, Д.Доломжав, ред.Ч.Төрбадрах.-УБ.,2022.-77х.

Агуулга: Энэхүү стандартын онцлог, ач холбогдол, тавигдах шаардлагууд, түүнийг хэрэгжүүлэхэд баримтлах зарчмууд, хийж байх ёстой ажлуудын талаар судалж, мэдсэнээр өөр өөрсдийн ажлын чанарыг тогтвортой сайжруулж байхад энэхүү гарын авлага зориулагдсан.

Санхүүгийн зохицуулах хороо

Судалгааны товхимол №1.-УБ., 2020-326х.

Агуулга: Энэхүү товхимолд Санхүүгийн зохицуулах хорооноос сүүлийн жилүүдэд хийж гүйцэтгэсэн суалгааны ажлуудыг нэгтгэн хүргэж байгаа бөгөөд товхимолд орсон судалгаанууд нь санхүүгийн зах зээлийн хяналт, зохицуулалтын тогтолцоо, короновирус цар тахлын нөлөө, санхүүгийн зах зээл дэх технологи, санхүүгийн зах зээлийн реформ, үнэт цаасны зах зээл жижиг дунд үйлдвэр ба түүний санхүүжилт зэрэг сэдвүүдийг багтаасан.





Амаржаргал Д., Бүжинтуул Б.

Бизнесийн статистик. Бодлого, дасгалын хураамж.-УБ., 2022.-132х.

Агуулга: Энэхүү бодлого дасгалын хураамж нь менежмент, маркетинг, санхүү, нягтлан бодох бүртгэл, эдийн засаг болон бусад бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж буй оюутнуудад зориулагдсан.

Батхүрэл Г

Эдийн засгийн шинжлэх ухааны доктор, боловсрол судлалын ухааны доктор, профессор, Монгол улсын гавъяат эдийн засагч Г.Батхүрэлийн удирдлагаар эрдмийн зэрэг хамгаалсан эрдэмтдийн бүтээл /ред. Г.Баттүвшин.-УБ., 2019.-427х.

ISBN: 978-99978-57-62-0

Агуулга: Энэ бүтээлд профессор Г.Батхүрэлийн сүүлийн эрдэм судлалын өгүүллэгүүдээс гадна, түүний удирдлагаар эрдмийн зэрэг хамгаалсан доктор шавь нарынх нь шинжлэх ухаанд оруулсан хувь нэмрийг тодорхойлсон бүтээлүүдийг багтаасан.





Үндэсний статистикийн хороо

Үндэсний статистик. Эрдэм шинжилгээ, судалгааны сэтгүүл №16.УБ., 2022.-176х.

Золбаяр Ч.

Татварын нэр томъёоны тайлбар толь бичиг / эмхт. Ч.Золбаяр, ред. Ш.Цогзолмаа.-УБ., 2018.- 432х. ISBN: 978-99978-2-568-1

Агуулга: Энэхүү толь бичигт Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй татварын хуулиудын нэр томъёоны тодорхойлолт, холбогдох зүйл, хэсэг, заалтыг англи хэлээр орчуулан оруулж, олон улсад түгээмэл хэрэглэгддэг татварын нэр томъёог холбогддох мэдээллийн эх сурвалжаас түүвэрлэн эмхэтгэж монгол хэлнээ хөрвүүлсэн.





Буяннэмэх Х., Мижиддорж Н.

Микропроцессорын техникийн үндэс. Сурах бичиг.- УБ., 2014.-106х.

ISBN: 978-99973-46-69-8

Агуулга: Микропроцессорын үндсэн дээр микрокомпьютер, микропроцессорын систем зохион бүтээх шинжлэх ухаан техникийн салбар болох микропроцессорын техник нь орчин үеийн хамгийн эрчимтэй түргэн хөгжиж байгаа салбарын нэг юм.

Буяннэмэх Х.

Мехатроник системийн удирдлага ба хяналт /ред. Б.Хулганаа.- УБ., 2012.- 87х.





Содномдорж Н.

Орчин үеийн хөдөлмөрийн эдийн засаг. Сурах бичиг : боть: 1,2 /ред. С.Гүндсамба, С.Санасэр, С.Дамбий, С.Норов.-УБ., 2021.-1085х ISBN: 978-9919-25-148-2

Агуулга: Энэхүү сурах бичиг нь хөдөлмөр, түүний зах зээл, хөдөлмөрийн харилцаа, хөдөлмөр эрхлэлт, хүний нөөц боломжийн ашиглалт (хөдөлмөрийн бүтээмж, ажилгүйдэл), цалин хөлс, урамшуулал, тэдгээрийн бодлогыг хүний хөгжил, хүний нөөцийн менежмент, хөдөлмөр хүн ам зүйтэй уялдуулан судалдаг барууны эдийн засгийн ололтыг ашиглаж, юуны өмнө хөдөлмөрийн эдийн засгийн онолын чиглэлийг судлахад зориулагдсан.

Баярсайхан Б.

Мехатроник: мэдрүүр ба гүйцэтгэх төхөөрөмж.-УБ.,2012-32х.

Агуулга: Энэхүү гарын авлагад мехатроник системийн үүсэл хөгжил, түлхүүр элементүүд, тэдгээрийн судалгааны чиглэл, мехатроникийн бүрэлдэхүүн хэсгүүдийн нэг болох мэдрүүр ба гүйцэтгэх төхөөрөмж, тэдгээрийн ангилал, ажиллах, зарчим, цаашдын хөгжлийн чиг хандлага зэргийг багтаасан болно.





Батдорж Ч., Хишигт Н., Чулуун С.

**Монгол улсын шинжлэх ухааны түүх / ред. Д.Рэгдэл, Б.Чулуунбаатар.-УБ.,2021.-280х.
ISBN: 978-9919-9768-3-5**

Агуулга: Судар бичгийн хүрээлэнгийн үүсэл хөгжлийн түүхэн үйл явц, эрдэм судлалын ажлын үндсэн чиглэл, цар хүрээ, үр дүн гадаад харилцаа хамтын ажиллагаа, нийгмийн амьдралд гүйцэтгэсэн үүргийн талаар архив болон судалгаа шинжилгээний ажлын баялаг эх сурвалжид тулгуурлан боловсруулсан нэлээд цогц мэдлэг сонирхолтой мэдээллийг оруулсан

Монгол улсын шинжлэх ухааны академи

**Монгол улсын шинжлэх ухааны түүх. : Баримт, гэрэл зургийн цомог /эмхт. С.Чулуун, Ч.Батдорж, Б.Нацагдорж., ред. Д.Рэгдэл .-УБ., 2021.- 440х.
ISBN: 978-9919-9768-3-5**

Агуулга: Энэхүү бүтээл нь Монгол улсад орчин цагийн шинжлэх ухааны эх суурь Судар бичгийн хүрээлэн байгуулагдсан түүхэн цаг үеэс эхлэн өнөөг хүртэлх орчин цагийн шинжлэх ухааны түүхийг харуулсан түүхэн баримт, эх хэрэглэгдэхүүн, гэрэл зургаас бүрдсэн цомог болно.





Төсөвт байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг /эмхт. Ш.Отгон., Ред. Д.Нямаа.-УБ.,2020.-199х. ISBN: 978-9919-20-974-2

Агуулга: Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь НББ хөтөлж, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах ажиллагаатай холбоотой Монгол улсын хууль тогтоомж, журам болон Улсын Секторын НББ-ийн Олон улсын Стандарт, Монгол улсын Сангийн Сайдын тушаалаар баталсан журам, заавар аргачлалын шаардлагад нийцсэн болно.

Цэргийн алба хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн хууль тогтоомжийн эмхэтгэл.: Албан ажлын хэрэгцээнд / ред. Д.Ганхуяг., Г.Өнөрбаяр.-УБ.,2020.-294х.

Агуулга: Энэхүү эмхэтгэлд зэвсэгт хүчин, хилийн ба дотоодын цэрэг, онцгой байдлын зэрэг төрөлжсөн байгууллагад алба хаасан цэргийн албан хаагчид тэтгэвэр, тэтгэмж тогтоолгон авах эрхтэй холбоотой харилцааг зохицуулсан хуулиуд, түүнийг хэгэгжүүлэхтэй холбогдон гарсан тогтоол, шийдвэр тушаал, журам дүрэм, заавар аргачлал, жишээ, тайлбарыг тус тус багтаасан болно.





Нийгмийн даатгалын нийгмийн маркетинг гарын авлага
/ред. Г.Саран., Д.Цэцэгбадам.-УБ., 2019.-180х.
ISBN: 978-9919-22-902-3

Агуулга: Төслийн хүрээнд нийгмийн даатгалын байгууллагын зорилго, чиг үүргийг хангахад мэргэжил аргазүй туслалцаа үзүүлэн олон нийтийг нийгмийн даатгалын талаарх мэдээллээр хангах, нийгмийн даатгалын ажилтнуудад нийгмийн маркетингийн онол аргазүйн асуудлаар ойлголт өгөхөд чиглэсэн.

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой тушаал, шийдвэрийн эмхэтгэл / эмхт. Г.Анхбаяр, ред. П.Мөнхтулга.-УБ.,2019.-235

Агуулга: Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцогч талууд, эрүүл мэндийн байгууллагын эмч, мэргэжилтнүүд, даатгуулагч / иргэн/-ийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын талаархи шинэчилсэн болон шинээр батлагдсан дүрэм, журам, зааврын талаар зохих мэдлэгтэй болгох, нийгмийн даатгалын сангаас холбогдох тэтгэвэр тэтгэмж, төлбөр авах эрхээ эдлэхэд нь туслах зорилгоор боловсруулсан.





Хяналт шалгалтын үйл ажиллагаатай холбоотой хууль, тогтоомж зарим тушаал шийдвэр / эмхт. Л.Цэрэндулам, ред. Д.Ганзориг.-УБ., 2019.-224х.

Агуулга: Уг эмхэтгэлд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль, Засгийн газрын 2014 оны 354 дүгээр тогтоолоор баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын дүрэм,” Нийгмийн даатгалын байцаагчийн дүрэм,” Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 186 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын байгууллагын хяналт шалгалтын нэгдсэн заавар,” 2019 оны А/30 дугаар тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтооход шаардагдах баримт бичгийг бүрдүүлэх, хянах журам,” 2019 оны А/50 дугаар тушаалаар баталсан “Цахим хяналт шалгалтын ажлын заавар” зэрэг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зарим эрх зүйн баримт бичгүүдийг орууллаа.

Нийгмийн даатгалын орлого шимтгэл хариуцсан байцаагчийн ажлын гарын авлага / ред. Г.Саран, Б.Даваахүү, Ц.Эрдэнэтуяа.-УБ., 2020.-84х.

Агуулга: Энэхүү гарын авлага нь шинээр ажилд орж байгаа болон орлого шимтгэлийн байцаагчаар ажиллаж буй ажилтнуудад өдөр тутмын ажилд хэрэглэгдэнэ.





Монгол улсын нийгмийн хамгааллын олон улсын хэлэлцээртэй холбогдолтой хууль / ред. Б.Ундрал.-УБ.,2020.-238х

Агуулга: Энэхүү эмхэтгэлд Нийгмийн даатгалын тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Нийгмийн даатгалын сангаас олгох ажилгүйдлийн тэтгэмжийн тухай хууль, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Олон улсын гэрээний тухай хууль болон Монгол улсаас Зөвлөлт Социалист Солонгос Улс, Унгар, Польш, Чех, Турк улсын хооронд байгуулсан Нийгэм хангамжийн болон нийгмийн хамгааллын салбарт хамтран ажиллах тухай хэлэлцээр, уг хэлэлцээрийг хэрэгжүүлэхтэй холбогдох Засгийн газрын тогтоол, нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал, журам, аргачлалыг тус тус багтаан орууллаа.

Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын тухай хууль тотоомжийн эмхэтгэл: Ажил, олгогч, даатгуулагч, иргэн, нийгмийн даатгалын байцаагч, ажилтнуудад зориулав / ред. Б.Ундрал, Б.Батжаргал.-УБ., 2019.-156х.

Агуулга: Энэхүү эмхэтгэлд Нийгмийн даатгалын сангаас олгох үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын болон Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаалаар батлагдан хүчин төгөлдөр мөрдөж буй дүрэм, журам, зааврыг багтаан орууллаа.





Нийгмийн даатгалын статистикийн эмхтгэл /эмхт. Б.Энхболор, ред. Ц.Ганцэцэг.-УБ., 2017.-171х.

Агуулга: Энэхүү эмхэтгэлд өмнөх жилүүдэд гаргаж байсан нийгмийн даатгалын статистик үзүүлэлтүүдийг өргөтгөн нийгэм хангамжийн зардал, холбогдох мэдээллийг 1943-1945, 1950, 1970, 1980, 1990-1994, 1995-2016 оны байдлаар харуулсан. Зарим үзүүлэлтүүдийг илүү ойлгомжтой болгох зорилгоор дүрслэл, зургаар илэрхийлэв.